

СКАУТЫН ЗУСЛАН ЦУГЛАРАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ

Ерөнхий шаардлага

Зорилго: Энэхүү стандартын зорилго нь скаутын зусланг хөгжүүлэх, мэргэшсэн, ур чадвартай боловсон хүчнээр хангах, хүүхдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, бүлгийн ажлаар олж авсан мэдлэгийг батжуулах, шинэ мэдлэг мэдээлэл авах, хүүхэд бие даан хамт олныхоо дунд хөгжих, оролцооны эрхийг нь хангах, хүүхдэд таатай орчин бүрдүүлэх, эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангах, техникийн аюулгүй байдлын шаардлага хангасан унаагаар үйлчлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх, галын болон бусад гэнэтийн ослын үед тусламж үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлагыг тогтооход оршино.

Хамрах хүрээ: Энэхүү стандарт нь скаутын зуслан, цугларалт зохион байгуулах Үндэсний зөвлөлийн гишүүн, удирдах ажилтан, арга зүйч, бүлгийн удирдагч, хөтөлбөрийн удирдагч, хүүхэд, эцэг эх, хамтран ажиллах байгууллага, хувь хүмүүсийг хамарна.

Нэг . Норматив ишлэл

1.1 Нэр томьёо, тодорхойлолт

- 1.1.1 **Скаутын зуслан:** Скаут гишүүд юу мэдэж сурсан зүйлээ шалгуулах, өөрийн авхаалж самбааг сорьсон шалгууруудыг өгөх, шинэ зүйлийг мэдэж авах, тэдний амрах, хөгжих, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлсэн, скаутын арга зарчмаар бүлэг, бүлгэмийн хэмжээнд зохион байгуулж байгаа майхант үйлчилгээг зуслан гэнэ.
- 1.1.2 **Скаутын цугларалт:** Скаут гишүүд хоорондоо танилцан нөхөрлөх, хамтран шинэ зүйлийг мэдэж сурч авах, чөлөөт цагаа хөгжилтэй, зугаатай өнгөрүүлэх замаар өөрсдийгөө хөгжүүлэх, скаутын арга зарчмаар хэд, хэдэн бүлгэм, аймаг, дүүргийг хамруулан зохион байгуулах үйл ажиллагааг Скаутын цугларалт гэнэ.

1.2 Скаут зуслан, цугларалтын хүний нөөц

- 1.2.1 Скаутын зуслан, цугларалтыг скаутын хөдөлгөөн, боловсролын байгууллагад сүүлийн 3-аас доошгүй жил ажилласан, 2 модон тэмдэгттэй, манлайлах ур чадвар сайтай удирдагч багш удирдан зохион байгуулна

- 1.2.2 Скаутын зуслан, цугларалтанд скаутаар мэргэшсэн, ёс зүй, харилцааны соёлтой, зохион байгуулах, манлайлах ур чадварыг өндөр түвшинд эзэмшсэн бүлгийн удирдагч багш нар ажиллана
- 1.2.3 Зуслан, цугларалтын үеэр мэргэжлийн эмч, харуул хамгаалалтын хүнийг заавал ажиллуулна.
- 1.2.4 Скаутын зуслан, цугларалтанд ажиллах сайн дурынхныг бэлтгэх сургалтанд хамрагдсан байна.
- 1.2.5 Скаутын зуслан цугларалтанд ажиллаж байгаа сайн дурынхан МСХ-ны насанд хүрэгчдийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

Хоёр. Скаутын зуслан цугларалтын үеэр хоол хүнсэнд тавигдах шаардлага

- 2.1 Хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүн нь чанар эрүүл ахуйн аюулгүйн баталгаажуулалтад хамрагдсан, шинжилгээ дүгнэлттэй байна.
- 2.2 Хот суурин газраас хоол хүнсний бүтээгдэхүүнийг зориулалт, шаардлагын дагуу тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ.
- 2.3 Зөөврийн ундны ус нөөцлөх савыг 3 хоног тутамд угааж ариутгана
- 2.4 Зуслан цугларалтын үеэр түргэн муудах хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын сав, байранд хадгална.

Гурав. Скаутын зуслан, цугларалтанд оролцогчдыг тээвэрлэхэд тавигдах шаардлага

- 3.1 Оролцогчдыг зуслан, цугларалтанд ирэхэд болон зуслан, цугларалтаас буцахад нь монгол улсын замын хөдөлгөөний дүрэмд заасан аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан тээврийн хэрэгсэлээр үйлчилнэ.
 - 3.1.1 **Тээврийн үйлчилгээний зохион байгуулалт :**
 - 3.1.2 Хүүхэд тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл доторх хүүхдийг эмх журамтай зохион байгуулалттай авч явахыг тухайн үед томилогдсон багш нар хариуцна. Автобус бүр багштай явна.
 - 3.1.3 Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл бүр цувааны дугаартай, “Хүүхэд” гэсэн анхааруулах тэмдэгтэй, “Цуваа” гэсэн бичигтэй байна.

- 3.1.4 Тээврийн хэрэгсэлүүд цуваагаар явах журмыг баримтлана
- 3.1.5 Хүүхэд цуваанаас хоцрохоос сэргийлж цуваа хөдлөх тухай сануулгыг зарлаж мэдээлнэ
- 3.1.6 Хүүхдүүдийг нас, биеийн байдалд тохируулан хувиарлалтыг хийх бөгөөд нэг автобусанд суух хүүхдийн тоог тогтоосон байна
- 3.1.7 Жолооч нь хүүхэд тээвэрлэлтийн үед шаардлага гарвал хүүхдэд анхан шатны тусламж үзүүлж, эмнэлэгт хүргэнэ
- 3.1.8 Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэлд гадны зорчигч суулгах, ачаа ачихыг хориглоно

3.2 Хөдөлгөөний хяналт

- 3.2.1 Хүүхэд тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь хөдөлгөөнд оролцохдоо Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн заалтын дагуу 50 км/ц-ийн хурдтай явна.
- 3.2.2 Хүүхэд тээвэрлэсэн тээврийн хэрэгслэлүүдийг хүүхэд бууж суухад саад болохгүйгээр паркалж тавина.
- 3.2.3 Зуслан, цугларалтын эзэмшил газрын бүсэд автомашины зогсоолыг тогтоож тэмдэгжүүлсэн байна.

Дөрөв. Скаут зуслан, цугларалтын эрүүл мэндийн үйлчилгээ

- 4.1.1 Зуслан, цугларалтын эрүүл мэндийн үйлчилгээнд зуслан, цугларалтын амрагч хүүхэд, багш ажилтан хамрагдана.

4.2 Эрүүл мэндийн үйлчилгээ

- 4.2.1 Хүүхэд амрах, хөгжих, чийрэгжих эрүүл орчинг бүрдүүлнэ.
- 4.2.2 Урьдчилан сэргийлэх үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд анхны болон яаралтай тусламж үзүүлнэ.
- 4.2.3 Эрүүл мэндийн үйлчилгээг мэргэжлийн эмч, сувилагч үзүүлнэ.
- 4.2.4 Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулна
- 4.2.5 Хүүхдүүдийг аялалд явахын өмнө нэмэлт үзлэг хийж, зөвлөгөө өгнө.

4.2.6 Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж

- 4.2.7 Өвчилсөн хүүхдийг эмнэлгийн тусламжийн бүртгэлд бүртгэж, анхан шатны тусламж үзүүлсэн тухай тэмдэглэнэ

- 4.2.8 Эмнэлэгт хүргэх шаардлагатай бол цаг алдалгүй хүргэж өгөх ба эмч, бүлгийн удирдагч, хариуцаж буй насанд хүрэгч хамт явна
- 4.2.9 Тусламж үзүүлэхдээ хүүхдийн биед харшилдаг эм тариа байдаг эсэхийг тодруулж тэмдэглэсэн байна.
- 4.2.10 Хүүхдийн өвчлөлийн тухай эцэг эх, асран хамгаалагчид заавал мэдэгдэж цаашдын эмчилгээний зөвшөөрлийг авна
- 4.2.11 Хүүхэд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай бол эцэг эх, асран хамгаалагчийн асрамжинд үлдээнэ.

Тав. Скаутын зуслан, цугларалтын аюулгүй байдал

5.1 Ерөнхий шаардлага

- 5.1.1 Амрагч хүүхдүүдийн майхан асарт хялбар гал авалцан шатах, тэсэрч дэлбэрэх бодис материал хадгалахыг хориглоно.
- 5.1.2 Хүүхдүүдийн чөлөөтэй амрах, хөгжих бололцоо нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэрийнхээ Цагдаагийн газар, хэлтэс, хамгаалалтын албатай хамтран, төлөвлөгөө гарган, гэрээ байгуулж ажиллана.
- 5.1.3 Зуслан, цугларалтын үеэр болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж холбогдох техник хэрэгслийг бэлэн байлгана.

Зургаа. Скаут зусланд хориглох зүйл

- 6.1 Зуслангийн бүсэд, хотхонд, майханд скаут хүүхдүүд, бүлгийн удирдагчид, багш, зуслангийн ажилтнууд, тамхи болон согтууруулах ундаа хэрэглэх
- 6.2 Майханд спирт, бензин, газ зэрэг хялбар шатах бодис материал хадгалах, авч орох
- 6.3 Мөн майханд ил хамгаалалтгүй лаа асаах, хэрэглэх
- 6.4 Зуслангийн ногоон бүс, хотхон, хүүхдийн амралтын орчинд гаднын хүмүүсийг зөвшөөрөлгүй нэвтрүүлэх, мал, машин, мотоцикль, унадаг моторт дугуйтай явах
- 6.5 Зуслангийн талбай болон түүний ойр орчим, хотхонд тогтоосон газраас өөр газарт зөвшөөрөлгүйгээр түүдэг асаах, галын наадам хийх
- 6.6 Скаут хүүхдүүд зөвшөөрөлгүйгээр ойруу орох, зугаалах, самар жимсэнд явах
- 6.7 Гол нуур, цөөрмийн усанд тогтоосон аюулгүйн бүсээс гадна усанд орох

- 6.8 Хүүхдийн ар гэрээс эргэлтээр ирсэн хялбар муудах, хадгалалтын хугацаа нь дууссан, эрүүл ахуй, чанарын шаардлага хангаагүй хүнсний зүйл, согтууруулах ундааны зүйл дотогш нэвтрүүлэх
- 6.9 Мансууруулах эм бэлдмэл, согтууруулах ундаа, тамхи, скаут хүүхдүүдэд худалдах, сурталчлах

Долоо. Скаутын зуслан, цугларалтыг зохион байгуулах зөвшөөрөл, хяналт шалгалт

Скаутын зуслан, цугларалт нь скаутын хөдөлгөөний үндсэн үйл ажиллагааны нэг бөгөөд түүний нэрийг ашиглан ашиг олох зорилгоор болон чанар муутай зохион байгуулснаас Скаутын нэр хүнд унах асуудлаас зайлсхийх үүднээс зөвшөөрлийг заавал авч Скаутын гэсэн тодотголыг авах эрх нээгдэнэ.

- 7.1 Скаутын Зусланг зохион байгуулахдаа бүлгэмийн удирдагч аймаг, дүүргийн Скаутын Даргад мэдэгдэн үйл ажиллагааны хөтөлбөр, стандартыг хангасан мэдээллийг өгч зөвшөөрөл авах ба энэ тухай ҮТШ-т албан ёсоор мэдэгдсэн байна.
- 7.2 Скаутын цугларалтыг зохион байгуулахдаа Монголын Скаутын Холбооны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан байх ба стандартыг хангасан тухай мэдээллээ Үндэсний Төв Штабт мэдэгдэж албан ёсоор зөвшөөрөл авна.
- 7.3 Скаутын Зуслан, цугларалтанд оролцогчдын зардлын үнэлгээг тогтоохдоо Үндэсний Төв Штабтай зөвшилцсөн байна.
- 7.4 Скаутын зуслан, цугларалтыг зохион байгуулах тухай мэдэгдэл ирсний дараа аймаг, дүүргийн Скаутын Зөвлөл болон Үндэсний Төв Штабаас холбогдох шалгалтыг хийж дүгнэлт гаргах ба үйл ажиллагааны дараа санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг 14 хоногийн дотор ҮТШ ирүүлж байна.